




Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
Статистик Тандалт Судалгааны Алба




ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН ЭРГЭН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот


2023 он

ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ 2023 ОНЫ I УЛИРАЛ


Монгол улсын хэмжээнд 2023 оны I улиралд гэмтэл хордлого гадны шалтгаант 45023 шинэ тохиолдол бүртгэгдэж, үүнээс 675 тохиолдол нас барсан байна. Энэ нь сүүлийн хоёр жилтэй харьцуулж үзэхэд өсөж буй үзүүлэлт ажиглагдаж байгаа ба тухайлбал осол гэмтлийн шалтгаант өвчлөл өмнөх оны мөн үеэс 15.4%-иар өсөж, нас баралт 6.4%-иар буурсан байна.



Бүртгэгдсэн нийт тохиолдлыг хүйсээр авч үзвэл 57.6% /25931/ нь эрэгтэй, 42.4% /19092/ нь эмэгтэй байна.



Осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн хамгийн их хувийг 0-4 насныхан эзэлж байна. Мөн 30-34 болон 10-14 насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад тохиолдлын тоо өндөр байна.




Монгол улсын хэмжээнд 2023 оны эхний улиралд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант өвчлөлийг уналтын шалтгаан тэргүүлсэн хэвээр байгаа буюу 21413, 2-рт амьгүй механик хүчинд өртөх гэмтэл 6420, 3-рт хүчирхийлэл 4328, 4-рт зам тээврийн осол 3855, 5-рт амьтай механик хүчинд өртөх гэмтэл 3550 тохиолдол байна.

Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан


Уналт	Амьгүй механик хүчинд өртөх	Дайралт, халдлага	Зам тээврийн осол	Амьтай механик хүчинд өртөх
				
21413	6420	4328	3855	3550
W00-W19	W20-W49	X85-Y09	V01-V99	W50-W64
Шат, ор, сандал, цана, чарга, барилга байгууламж, халтирч тээглэх гэх мэт бүх төрлийн уналт	Дарагдах, цохигдох, мөргөх, зүсэгдэх гэх мэт бүх төрлийн амьгүй механик хүчний үйлчлэлээр гэмтсэн тохиолдол	Хүн хоорондын, гэр бүлийн гэх мэт хүчирхийллийн улмаас гэмтсэн бүх тохиолдол	Бүх төрлийн тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн осол болон мориноос унаж гэмтсэн тохиолдол	Бүх төрлийн амьтай механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдол/ хүн амьтанд маажуулах, нохойд хазуулах, мал амьтанд дайруулах мөргүүлэх, өшиглүүлэх




Осол гэмтэлд өртөж буй нийт тохиолдлын 46.2%-ийг бүрэн дунд боловсролтой хүмүүс эзэлж байгаа бол 22.0% нь боловсролгүй буюу 0-15 насны хүүхэд байна.



2023 оны 1-р улиралд осол гэмтлийн шалтгаанаар гэмтсэн нийт тохиолдлын 8.6% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн байдал өмнөх оны мөн үеэс 6.7%-иар өссөн бөгөөд сард 1200 гаруй тохиолдол согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртөж байна.




Гэртээ байхдаа осол гэмтэлд өртөх тохиолдол аль ч үед хамгийн өндөр хувийг 37.7% /16990/ эзэлдэг бол гудамж, зам, гадаа гэмтэх нь 30.5%-тай байна.



Нийт гэмтсэн тохиолдлын 84.8% нь нийслэлд бүртгэгдсэн бол 15.2% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Нийслэлд бүртгэгдсэн тохиолдлын 94.1% ГССҮТөвийн яаралтай тусламжийн тасгаас тусламж үйлчилгээ авчээ.




2023 оны I улиралд осол гэмтлийн шалтгаант өвчлөл төвийн бүс /2383/ болон Дорноговь аймагт /690/ бусад аймгуудаас өндөр, Говьсүмбэр аймагт /90/ цөөн тохиолдол бүртгэгдсэн байна.



ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ

2023 оны 1-р улиралд 675 осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4% буурсан үзүүлэлттэй байна. Сар тус бүрийг өмнөх онтой харьцуулахад нас барсан тохиолдлын тоо 4.5-8.7 хувь хүртэл буурсан байна.



Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 75.8% /512/ нь санамсаргүй осол, 22.7% /153/-ийг санаатайгаар үйлдэгдсэн осол эзэлж байсан бол 1.5%-ийг шалтгаан тодорхойгүй нас баралт эзэлсэн байна.

Гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралт



Санаатай осол гэмтэл

/Амиа хорлолт болон дайралт, халдлагын шалтгаан осол гэмтэл/



Санамсаргүй осол гэмтэл

/Уналт, зам тээврийн осол, амьгүй болон амьтай механик хүчинд өртөх, усанд живэлт, түлэгдэлт, хордолт гэх мэт/



Осол гэмтэл, гадны шалтгаанаар нас барсан нийт тохиолдлыг санамсаргүй хордох, хорт бодист /эмийн болон эмийн бус бодис/ өртөх тохиолдол 35.9%, амиа хорлолт 16.3%, байгалийн хүчинд өртөх /хөлдөлт, осголт/ 14.8%, зам тээврийн осол 11.1%, уналт 7.1% зэрэг үзүүлэлттэйгээр нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд багтаж байна.



Шалтгаан тус бүрээр өмнөх оны 1-р улиралтай харьцуулахад амьгүй механик хүчинд өртөх 41.2%, амьтай механик хүчинд өртөх болон усанд живэлт 100%, түлэгдэлт 11.8%, хордолт 7.9% тус тус өсөлтийн хувь буурсан байгаа бол зам тээврийн осол 3.7%, амьсгал боогдох осол 2.6%, байгалийн хүчинд өртөх 32.1% амиа хорлолт 3.8% өссөн үзүүлэлттэй байна. Шалтгаан тус бүрээр тухайн онд эзлэх хувь болон нийт тохиолдлын өсөлтийн хувийг дээрх хүснэгтээс харна уу.


Осол гэмтлийн шалтгаан	2022 Эзлэх хувь	2023 Эзлэх хувь	Өсөлтийн хувь
Зам тээврийн осол	10.7	11.1	3.7
Уналт	5.8	7.1	22.4
Амьгүй механик хүчинд өртөх	1.7	1	-41.2
Амьтай механик хүчинд өртөх	0.3	0	-100.0
Усанд живэлт	0.1	0	-100.0
Амьсгал боогдох	3.9	4	2.6
Түлэгдэлт	1.7	1.5	-11.8
Байгалийн хүчинд өртөх	11.2	14.8	32.1
Хордолт	39	35.9	-7.9
Амиа хорлолт	15.7	16.3	3.8
Хүчирхийлэл	6.7	6.4	-4.5
Тодорхойгүй	3.3	1.9	-42.4




Нас барсан нийт тохиолдлын 76.6% /517/-ийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд осол гэмтлийн улмаас амь насаа алдаж буй 10 хүн тутмын 8 нь эрэгтэйчүүд байна.



Гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтыг насны бүлгээр авч үзэхэд 2022 оны 1-р улиралд 45-49 насныхан тэргүүлж байсан бол 2023 онд 40-44 насанд нас баралт тэргүүлж байна. Мөн 0-9, 40-44, 65+ насанд өмнөх оны үзүүлэлттээс өссөн үзүүлэлттэй байна.




Нас баралт бүртгэгдсэн харьяаллаар



Осол гэмтлийн шалтгаант нас баралт бүртгэгдсэн харьяаллаар харвал 60.1% /406/ нийслэлд бүртгэгджээ.



Осол гэмтлийн шалтгаант нас баралт Хангайн бүсд /90/ бусад бүсээс өндөр бүртгэгдсэн байна. 21 аймгийн хэмжээнд нас баралт Төв аймагт /24/ өндөр, Говьсүмбэр аймагт /2/ хамгийн бага бүртгэгдсэн байна.



Нийслэлийн эмнэлгүүдийн "Осол гэмтлийн шалтгаант өвчлөл"-ийн мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			Нийт			Мэдээний зөрүү	Баазын зөрүү
		Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ		
1	УНТЭ	24	24	24	38	38	38	20	20	20	82	82	82	0	0
2	УХТЭ	22	22	22	22	22	22	18	18	19	62	62	63	1	1
3	УГТЭ	3	3	3	3	3	3	3	3	3	9	9	9	0	0
4	ЭХЭМҮТ	32	32	32	35	35	35	50	50	50	117	117	117	0	0
5	ГССҮТ	11015	11015	11015	10756	10756	10756	14084	14084	14084	35855	35855	35855	0	0
6	СЭМҮТ	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	1	1	1
7	Мөнгөнгүүр	15	15	15	33	33	33	21	21	21	69	69	69	0	0
8	Интермед	14	14	14	20	20	0	16	16	36	50	50	50	0	0
9	МЯСЭ										0	0	0	0	0
10	Асралт мед										0	0	0	0	0
11	МВГ	0	0	0	4	4	4	0	0	0	4	4	4	0	0
12	ЦТЭ	183	183	183	154	154	154	203	203	203	540	540	540	0	0
13	ТТАХНЭ	21	21	21	12	12	12	34	34	34	67	67	67	0	0
14	ТЗНЭ	3	3	3	8	8	8	7	7	7	18	18	18	0	0
15	ХТС										0	0	0	0	0
16	БГДЭМТ	0	0	0	0	0	0	1	1	5	1	1	5	4	4
17	БЗДЭМТ	5	5	5	9	9	9	24	24	24	38	38	38	0	0
18	БЗДНЭ	0	0	0	2	2	2	0	0	0	2	2	2	0	0
19	СБДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
20	СБДНЭ	0	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	0	0
21	СХДЭМТ	0	0	0	0	0	0	11	11	11	11	11	11	0	0
22	ХУДЭМТ	109	109	109	86	86	86	119	119	119	314	314	314	0	0
23	ЧДЭМТ	13	13	13	16	16	16	13	13	13	42	42	42	0	0
24	НАДЭМТ	30	30	30	0	0	0	50	50	50	80	80	80	0	0
25	БХДЭМТ	0	0		0	0		3	3	3	3	3	3	0	0
26	БНДЭМТ	53	53	53	72	72	72	80	80	80	205	205	205	0	0
27	Туул	2	2	2	4	4	4	3	3	3	9	9	9	0	0
28	Хонхор	0	0	0	7	7	7	3	3	3	10	10	10	0	0
29	Жаргалант	9	9	5	6	6	9	7	7	14	22	22	28	6	6
30	Гачуурт	6	6	6	6	6	6	12	12	12	24	24	24	0	0
31	Наркологи	23	23	23	12	12	12	45	45	45	80	80	80	0	0
32	Энэрэл	3	3	0	19	19	19	14	14	14	36	36	33	-3	-3
	Нийт	11585	11585	11579	11324	11324	11307	14842	14842	14874	37751	37751	37760	9	9

Орон нутгийн эмнэлгүүдийн “Осол гэмтлийн шалтгаант өвчлөл”-ийн мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			Нийт			Мэдээний зөрүү	Баазын зөрүү
		Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ		
1	Архангай	170	170	170	229	229	229	250	250	250	649	649	649	0	0
2	Баян-Өлгий	46	46	46	57	57	57	65	65	65	168	168	168	0	0
3	Баянхонгор	76	76	76	104	104	104	126	126	126	306	306	306	0	0
4	Булган	52	52	52	73	73	73	69	69	69	194	194	194	0	0
5	Говь-Алтай	60	60	60	78	78	78	69	69	69	207	207	207	0	0
6	Говьсүмбэр	18	18	13	28	28	33	42	42	42	88	88	88	0	0
7	Дархан-Уул	123	123	123	115	115	115	83	83	83	321	321	321	0	0
8	Дорноговь	256	256	256	179	179	179	243	243	243	678	678	678	0	0
9	Дорнод	100	100	100	102	102	102	88	88	88	290	290	290	0	0
10	Дундговь	31	31	31	75	75	75	48	48	48	154	154	154	0	0
11	Завхан	144	144	144	84	84	84	151	151	151	379	379	379	0	0
12	Орхон	53	53	53	55	55	55	73	73	73	181	181	181	0	0
13	Өвөрхангай	142	142	142	177	177	177	146	146	146	465	465	465	0	0
14	Өмнөговь	93	93	93	105	105	105	124	124	124	322	322	322	0	0
15	Сүхбаатар	101	101	101	107	107	107	91	91	91	299	299	299	0	0
16	Сэлэнгэ	110	110	110	105	105	105	124	124	124	339	339	339	0	0
17	Төв	104	104	104	131	131	131	161	161	161	396	396	396	0	0
18	Увс	120	120	120	76	76	76	65	65	65	261	261	261	0	0
19	Ховд	30	30	30	29	29	29	48	48	48	107	107	107	0	0
20	Хөвсгөл	134	134	134	149	149	149	144	144	144	427	427	427	0	0
21	Хэнтий	127	127	127	116	116	116	123	123	123	366	366	366	0	0
	Нийт	2090	2090	2085	2174	2174	2179	2333	2333	2333	6597	6597	6597	0	0

Нийслэлийн эмнэлгүүдийн "Осол гэмтлийн шалтгаант нас баралт"-ын мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			Нийт			Мэдээний зөрүү	Баазын зөрүү
		Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ	Мэдээ	Бааз	НЭМГ ЭМХТ		
1	УНТЭ	0	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	0	0
2	УХТЭ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
3	УГТЭ	1	1	1	3	3	3	0	0	0	4	4	4	0	0
4	ЭХЭМҮТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
5	ГССҮТ	14	14	14	7	7	7	16	16	16	37	37	37	0	0
6	СЭМҮТ	1	1	1	0	0	0	0	0	0	1	1	1	0	0
7	Мөнгөнгүүр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
8	Интермэд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
9	ШШҮХ	73	73	73	101	101	101	154	154	154	328	328	328	0	0
10	МЯСЭ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
11	Асралт мед	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
12	МВГ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
13	ЦТЭ	1	1	1	4	4	4	1	1	1	6	6	6	0	0
14	ТТАХНЭ	0	0	0	1	1	1	0	0	0	1	1	1	0	0
15	ТЗНЭ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
16	ХТС	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
17	БГДЭМТ	1	1	1	2	2	0	2	2	2	5	5	3	-2	-2
18	БЗДНЭ	2	2	2	0	0	0	0	0	0	2	2	2	0	0
19	БЗДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
20	СХДЭМТ	0	0	0	0	1	1	2	1	1	2	2	2	0	0
21	СБДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
22	ХУДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
23	СБДНЭ	1	1	1	1	1	0	2	2	2	4	4	3	-1	-1
24	ЧДЭМТ	0	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	0	0
25	НАДЭМТ	4	4	4	5	5	5	3	3	3	12	12	12	0	0
26	БХДЭМТ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
27	БНДЭМТ	0	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	0	0
28	Туул	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
29	Хонхор	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
30	Жаргалант	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
31	Гачуурт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
32	Наркологи	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
33	Энэрэл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
34	Грийн хоум	1	1	1	0	0	0	0	0	0	1	1	1	0	0
	Нийт	99	99	99	124	125	122	183	182	182	406	406	403	-3	-3

Орон нутгийн эмнэлгүүдийн “Осол гэмтлийн шалтгаант нас баралт”-ын мэдээ болон цахим мэдээний сангийн бүрдүүлэлт

№	Эмнэлгийн нэр	1 сар			2 сар			3 сар			Нийт			Мэдээний зөрүү	Баазын зөрүү
		Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ	Мэдээ	Бааз	ЭМХТ		
1	Архангай	6	6	6	7	7	7	9	9	9	22	22	22	0	0
2	Баян-Өлгий	4	4	4	3	3	3	4	4	4	11	11	11	0	0
3	Баянхонгор	3	3	3	5	5	5	6	6	6	14	14	14	0	0
4	Булган	1	1	1	7	8	7	3	2	3	11	11	11	0	0
5	Говь-Алтай	4	4	4	1	1	1	6	6	6	11	11	11	0	0
6	Говьсүмбэр	0	0	0	2	2	2	0	0	0	2	2	2	0	0
7	Дархан-Уул	3	4	3	7	7	6	7	6	8	17	17	17	0	0
8	Дорноговь	5	5	5	2	2	2	5	5	5	12	12	12	0	0
9	Дорнод	2	2	2	4	4	4	10	10	10	16	16	16	0	0
10	Дундговь	1	1	1	0	0	0	4	4	4	5	5	5	0	0
11	Завхан	6	6	6	1	1	1	0	0	0	7	7	7	0	0
12	Орхон	3	3	3	4	4	4	5	5	5	12	12	12	0	0
13	Өвөрхангай	2	2	2	4	4	4	6	6	6	12	12	12	0	0
14	Өмнөговь	0	0	0	7	7	7	3	3	3	10	10	10	0	0
15	Сүхбаатар	2	2	2	9	9	9	5	5	5	16	16	16	0	0
16	Сэлэнгэ	5	5	5	6	6	6	4	4	4	15	15	15	0	0
17	Төв	4	4	4	17	17	17	3	3	3	24	24	24	0	0
18	Увс	0	0	0	3	3	3	2	2	2	5	5	5	0	0
19	Ховд	5	5	5	2	2	2	2	2	2	9	9	9	0	0
20	Хөвсгөл	3	3	3	9	9	9	7	7	7	19	19	19	0	0
21	Хэнтий	8	8	8	9	9	9	2	2	2	19	19	19	0	0
	Нийт	67	68	67	109	110	108	93	91	94	269	269	269	0	0

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээний санд сар бүр гарч буй нийтлэг алдааны тухай

ГССҮТөвийн СТСАлбаны мэргэжилтнүүд эмнэлгүүдийн осол гэмтлийн өвчлөл, нас баралтын сарын мэдээг цахимаар хүлээн авч Hinfo V3.0 программ дахь бүртгэлтэй тулган, бүртгэлийн болон логик алдаа байгаа тохиолдолд тухай бүрт нь хариу илгээдэг тул очсон и-мэйл-н дагуу мэдээний сангийн алдаагаа сар бүрдээ хянаж хэвшинэ үү!

/Дараах зүйлсийг анхан шатанд үзлэг хийн маягт хөтөлж буй эмч нартаа анхааруулна уу/

1. Регистрийн дугаар буруу орсон тохиолдолд нас, хүйс буруу бүртгэгдэх тохиолдол байна. Жишээ нь: 100-аас дээш настай хүмүүсийн ихэнх нь регистрийн дугаар буруу оруулсантай холбоотойгоор нас нь 100-р нэмэгдсэн буюу хүүхдүүд байх нь элбэг байдаг. Тиймээс 100-аас дээш настай хүмүүсийн бүртгэлээ үнэн эсэхийг нягталж хэвшинэ үү
2. 15 хүртэлх насны хүүхдүүд дунд, дээд боловсролтой болон аль нэг газар ажил эрхэлдэг гэсэн сонголт хийгдсэн байгаа эсэхийг шалгаж хэвших. Учир нь 5 настай хүүхдэд дээд боловсролтой, мөн 8 настай хүүхдэд ажил эрхэлдэг гэх мэт логикийн хувьд алдаатай бүртгэлүүд элбэг тохиолддог. Энэ нь хувь хүний мэдээллийн хэсгийг сайн шалгаагүйгээтэй холбоотой..
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдээлсэн тохиолдлууд дунд насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд үнэн эсэхийг заавал нягталсны дараа бүртгэх, мэдээлэх
4. Мансууруулах бодис хэрэглэсэн гэж сонгогдсон тохиолдолд заавал эргэн шалгах, лавлах
5. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгслээр явж байсныг зааж байгаа бөгөөд энэ нь арагш задарсан асуултын 1-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь: V тэмдэглэгээний ард 1 гэсэн болон эхний асуултад унадаг дугуйг сонгоно гэсэн үг юм. Явган зорчигч бол V үсэгний ард 0 байна гэх мэт.
6. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын 2-р тоо нь тухайн гэмтсэн хүн ямар тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөнийг зааж байгаа ба энэ нь арагш задарсан асуултын 3-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь: Суудлын машинтай явж байсан хүн шон мөргөөд түүнээсээ болж гэмтсэн бол 3 дахь асуултанд хөдөлгөөнгүй зүйл мөргөсөн гэдгийг сонгох ба V47-р кодолно.
7. Морь болон тэмээнээс унаж гэмтсэн тохиолдлыг ердийн хөсөгнөөс унасан буюу V80-р кодлох ба 2-р эгнээний асуултанд хариулахдаа жолооч, зорчигч гэх мэт сонголт огт хийхгүй. Зөвхөн уралдааны морь унаач эсвэл энгийн морь унаач гэсэн сонголтыг хийнэ.
8. Хүчирхийлэл буюу өвчний олон улсын ангиллаар Дайралт, халдлага X85-Y09-өөр кодлогддог шалтгаанд биеийн болон бэлгийн бүх төрлийн санаатайгаар нэгнээ гэмтээсэн тохиолдлууд орохыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл биеэрээ болон мод, чулуу, шил, хутга гэх мэт зэвсэг ашиглан зодолдсон тохиолдлууд орно. Зарим тохиолдолд бусдад зодуулсан хүмүүсийн гэмтлийн шалтгааныг W50-аар буруу кодолсон байна. Өвчний олон улсын ангиллаар W50 нь бусад хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, мушгиулах, хазуулах, маажуулах тохиолдлууд орох ба энэ нь зөвхөн санамсаргүй гэмтээсэн тохиолдолд л сонгогдох код гэдгийг анхаарна уу. Жишээ нь: Тоглож байгаад санаандгүй нэгнээ түлхэж унагаад гэмтээсэн, сагс тоглож байгаад санаандгүй маажуулсан, гараа эргүүлж байсан хүнд санаандгүй цохигдох зэрэг нь

- W50 ангилалд орно. Харин санаатайгаар цохисон, маажсан, өшиглөсөн бол хүчирхийлэл гэсэн ангилалд оруулна. Мөн яг юу ашиглан зодсоныг нь тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлт тайлбар бичнэ үү!
9. Түүнчлэн хүчирхийллийг кодлохдоо хэрэглэсэн арга зүйлээс нь хамаарч ялгаатай кодолдог болохыг анхаарна уу. Жишээ нь:
Санаатайгаар боосон бол Х91-р, хутгалсан бол Х99-р, мод чулуугаар цохисон бол У00-р, гар хөлөөрөө цохиж зодсон бол У04-р кодлоно.
 10. Түлэнхийн шалгаанаар W85-X19/ тусламж асан хүмүүст Т20-Т32-н хооронд онош тавих ёстой. Бүртгэгдсэн түлэнхийн тохиолдлууд дунд S-тэй оношууд байгааг анхаарна уу. Түүнчлэн яг юунд хэрхэн түлэгдсэн тухай “тусгай тэмдэглэл” багананд дэлгэрүүлэн бичнэ үү! Жишээ нь: халуун тогоотой зүйлд түлэгдсэн тохиолдлыг заавал тодруулан бичнэ үү
 11. “Тусгай тэмдэглэл” хэсэгт нэмэлт тайлбар шаардлагатай тохиолдлуудыг тэмдэглэх ба тухайн мөчид юу болсоныг тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлтээр бичнэ. Ингэснээр кодолж чадахгүй байгаа болон эргэлзээтэй тохиолдлуудаа тухай бүрт нь шийдвэрлэх ач холбогдолтой.

НИЙТИЙГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН АЛБАНД ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЖ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА.

Жишээ нь: гэр бүлээрээ болон олноороо явж байгаад зам тээврийн осолд орох, ажлын байр, гэр, байшин шатаж олон хүн түлэгдэх, байгалийн гамшиг тохиолдох, барилга байшин үйлдвэр уурхай нурах гэх мэтээс болж 4 болон түүнээс олон хүн 1 дор гэмтсэн, нас барсан тохиолдлуудыг сарын мэдээний хугацааг хүлээлгүйгээр тухай бүрт gemteltandalt@gmail.com хаягаар болон 70180132, 88765005, 80081049, 99475896 дугаарт мэдээлнэ үү!

Та бүхний мэдээлж буй “Осол гэмтлийн тохиолдол” бүрийн үнэн, зөв байдал нь цаашид осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн нэгж болдогийг онцгой анхааран эмч мэргэжилтнүүдээ зөвлөмж арга зүйгээр ханган ажиллана уу!

